

2025 он 09 сар 25 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот









Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг өөрчлөх, томилох тухай

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг шинээр томилох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дүгээр заалтыг үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Дашдаваа овогтой Хуланг 2025 оны 09-р сарын 24-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Цагаач овогтой Баатарсайханыг 2025 оны 09-р сарын 25-ны өдрөөс эхлэн томилсугай.
3. Шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Баатарсайхан/-д ТУЗ-ийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн чиглүүлэн, компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлж, тасралтгүй сайжруулж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэдээллийг Улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөн бүртгүүлж компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



	Ц.БААТАРСАЙХАН
	Б.АМАРСАЙХАН
	Д.ГЭРЭЛМАА
.....	А.ЖАРГАЛМАА
	Б.ОРГИЛ
	Ц.ОРГИЛБОЛД
	Д.ХУЛАН
	Д.ХҮРЭЛБААТАР
	Б.ЦЭЭНЯМ